



Монголын орчуулгын уламжлалын зарим асуудлыг хөндөхүй

Б.Энхбаяр* (МУИС)

Түлхүүр үгс: Орчуулга, орчуулгын онол, толь бичиг, гүүш орчуулагч, орчуулгын уламжлал

Энэхүү хурлыг зохион байгуулж буй МУИС-ийн ГХСС-ийн орчуулга зүйн профессорын багийнханд талархлаа илэрхийлье. Хурлаар уламжлалын асуудлыг хэлэлцүүлж байгаа нь цаг үеэ олсон чухал зүйл юм. Учир нь монголын ард түмэн үнэхээр орчуулгын баялаг уламжлалтай, өвөг дээдэс маань чадвартай, авьяаслаг орчуулагчид, дуун хөрвүүлэгчид байсан бөгөөд бидэнд агуу их өв үлдээсэн билээ. Харамсалтай нь, хуучин тогтолцоо буюу XX зууны үед монголчууд зөвхөн орос хэлнээс социалист үзэл суртал бүхий уран зохиол төдийхнийг орчуулж байсан бөгөөд сүүлийн хориод жилд л ардчиллын буянаар бусад олон хэлнээс зохиол бүтээл өргөнөөр орчуулах болсон мэт буруу ташаа ойлголт зарим залуусын дунд байдаг. Тэхээр бид урьд үеэ, өнгөрсөн түүхээ үгүйсгэх биш харин дахин сэргээж үнэн бодитоор нь хойч үедээ ойлгуулж үлдээх нь зүйн хэрэг. Үүнд энэ хурлын гол ач холбогдол оршино гэж мөхөс би үзэж байна.

Иймээс илтгэлдээ Монголын орчуулга өнө эртний уламжлалтайг хэдхэн зүйлээр тоймлон авч үзье.

Нэгд, Орчуулгын уламжлал

Монголчууд хэзээний орчуулгад элэгтэй, аль тэртээх 2000-3000 мянган жилийн өмнөх Хүннү, Сяньбийн үеэс орчуулга хийж байсан нь нэгэнт түүхийн баримтаар нотлогдсон байдаг. Өөрөөр хэлбэл, монголчууд бичиг үсэгтэй болсон үеэс монголын орчуулгын түүх эхэлсэн гэж үзэж болно. Эртний Хятадын их сэтгэгч Күнзийн Ачлалт ном зохиолыг бүр V зуунд тоба нар орчуулж байсан мэдээ байдаг. Мөн МЭӨ III зуунд Сяньби нарын орчуулсан 13 номын бүртгэлд ч Ачлалт номын нэр байдаг байна. Тоба улсын үед Энэтхэгээс лам хуврагууд ирж бурхан шашны холбогдолтой ном орчуулж байжээ.¹⁶⁵

*МУИС-ийн ОУХС-ийн Дипломат орчуулгын тэнхмийн эрхлэгч, профессор, доктор

¹⁶⁵Т.Сүхбаатар. Монголын эртний түүх: Сяньби, II боть, УБ, 2001, 130-р тал.

ХП-ХШ зуунаас орчуулгыг бодлогоор хөгжүүлж самгарди, хятад, уйгар, перс, төвд зэрэг дорно дахины олон хэлнээс ном зохиол орчуулж байжээ. Тухайлбал, 1264 онд Хубилай хааны зарлигаар хятад хэлнээс сонгомол зохиол орчуулах ба түүх зохиох хороо байгуулж 1306 онд дээрх хэл мэддэг 29 эрдэмтдийг цуглуулан орчуулгын ном зохиолыг хянах, орчуулах үүрэг оноож байв.

Дундад зууны үеийн Монголын орчуулгын нэртэй төлөөлөгч Чойжи-Одсэр, эрдэмтэн орчуулагч Шаравсэнгэ, Ойрдын зая Бандид Намхайжамц, Ширээт гүүш Цорж, бандид Гунгаа-Одсэр, Жанжаа хутагт Ролбийдорж, Дай гүүш Агваандампил, Урад гүүш Билигийн Далай, Ордосын Саган Цэцэн нар Алтангэрэл, Банзрагч судар, "Сайн үгт эрдэнийн сан Субашид, Үлгэрийн далай, Мялын дуулал, Панчатантра,, Эрдэнийн товч, Алтан товч, Цагаан түүх, Бигармижид хааны үлгэр, Гучин хоёр модон хүний үлгэр зэрэг бурхан шашны судар болоод эртний Энэтхэг, Хятад, Түвдийн уран зохиол, үлгэр, туульс тэргүүтэн өдий төдий зохиол бүтээл орчуулжээ. Зөвхөн Ойрдын зая бандид Намхайжамц гэхэд 200 шахам зохиол бүтээл орчуулсан мэдээ байна.¹⁶⁶

XVI-XVIII зууныг Монголын орчуулгын эрчимтэй хөгжлийн үе хэмээн эрдэмтэн судлаачид үздэг. Энэ үеийн зөвхөн Монголд төдийгүй, дэлхийд нэрд гарсан бүтээл болох 108 боть Ганжуур, 225 боть Данжуур их хөлгөн судруудын орчуулгыг дурдахгүй өнгөрөхийн аргагүй. Энэхүү олон боть агуу судруудыг манай гүүш орчуулагчид олон жилийн турш хүч хавсран нөр их хөдөлмөр зүтгэл гарган орчуулсны баримт өнөө ч хадгалагдаж байна. Эдгээр судруудыг түвд хэлнээс буулгасан хэдий ч "Монгол Данжуур нь түвд эхээсээ хамаагүй баялаг. Учир нь монгол гүүш орчуулагчид түвд эхэд байхгүй зарим текстийг самгарди болон хятад хэлнээс нэмж орчуулсан"¹⁶⁷ хэмээн Энэтхэгийн эрдэмтэн Локеш Чандра өндөр үнэлжээ.

Түүнчлэн Германы монгол судлаач Хейсиг "Монголын эзэнт гүрний түүх дайн тулаанаар дүүрэн хэдий ч Төв Азийн бусад улс түмэнтэй харьцуулахад хамаагүй их бүтээл туурвижээ."¹⁶⁸ хэмээн нэгэнтээ өгүүлжээ. Энэ бүхэнд бид хоосон омогших биш, харин бахархаж энэ уламжлалаа улам баяжуулан үргэлжлүүлэх үүрэгтэй. Ийнхүү Монголын гүүш орчуулагчид өөрсдийн бүтээлээр ард түмнээ Дорны соёлтой танилцах боломж олгохын сацуу орчуулгын арвин баялаг туршлагаа дараа дараагийн үедээ уламжлуулсаар ирсэн түүхтэй.

XX зуунд Монголын орчуулгын түүхэнд эргэлт гарч, орчуулга Дорно зүгийн соёлын хүрээнээс халин Өрнө болон Европын хэлнээс хийгддэг болсноор Монголын уншигчид Орос Европын соёлтой танилцаад зогсохгүй мэдлэгийн бүх салбар луу нэвтрэх боломжтой болсон билээ.

Энэ үеийн манай эрдэмтэн, зохиолч, орчуулагчид дэлхийн сонгодог ном бүтээлээс сорчлон орчуулж уншигч олондоо хүргэхдээ үгийн ураныг сонгож тухайн үндэстний ахуйн соёл, зан заншлыг монгол уншигчдынхаа ой тоонд буутал илэрхийлж орчуулгын онолын үндсэн зарчим, аргуудыг чадварлагаар хэрэглэн чанартай орчуулга хийдэг байлаа.

¹⁶⁶ Р.Гүрбазар. Орчуулгын онол дадлагын үндэс, УБ, 1996, 40-р тал.

¹⁶⁷ Lokesh Chandra. "Pilgrims of Shared Eternity", Mongolia-India: Spiritual Neighbours, New Delhi, Himala Publishers, 2000, p.33.

¹⁶⁸ B.Dashtseren. "The History and Culture of Mongolia", Calcutta, New Asian Printers, 1997, p.23.

Монголын орчуулга эрч далайцтай хөгжиж ирсэн 1821-1984 онд манай уншигчид 177 орны 12500 орчим бүтээлтэй орчуулгаар дамжин танилцсан гэсэн тоо гарчээ.¹⁶⁹

Хоёрт, толь бичгийн уламжлал

Монголчууд орчуулгын зэрэгцээ орчуулгын хамгийн эрхэм хэрэгсэл “багаж” болох толь бичиг зохиох ажилд тэртээ дундад зуунаас эхлэн ханцуй шамлан орж баталгаа юм.

Монголын гүүш орчуулагчдын бүтээсэн нэр томъёоны толь болох “Мэргэд гарахын орон нэрт тогтоосон даяг” нь зөвхөн толь бичиг төдийхнөөр зогсохгүй, орчуулгын сэтгэлгээнд томоохон хувь нэмэр оруулсан сор бүтээл хэмээн эрдэмтэн судлаачид үнэлдэг. “Мэргэд гарахын орон нэрт тогтоосон даяг”-ийг зохиоход XVIII зууны монголын алдарт орчуулагчид жанжаа хутагт Ролбийдорж, Дай гүүш Агваандампил, урад гүүш билгийн далай Шаравжамц, Тангад сургуулийн багш бүгдийг захирагч сайд үзэмчин Гомбожав нарын 40 орчим эрдэмтэн гүүш оролцож 1742 онд модон бараар хэвлүүлжээ. Ганжуурыг орчуулсан туршлагадаа тулгуурлан Данжуурыг орчуулахын өмнө газар газрын олон хэл, аялгатай гүүш орчуулагчдын үг хэллэгийг цэгцлэх, нэр томъёог жигдрүүлэх зорилгоор энэхүү толийг зохиожээ. Энэ бол монголын их орчуулагчид зөвхөн Данжуурыг орчуулахын тулд тогтоосон бус XVIII зуунаас урагш олон зуун жилээр орчуулга хийж хуримтлуулсан их туршлагын үр дүн мөн гэж орчуулагч Ц.Шүгэр үнэлжээ.

Монголын эзэнт гүрний үеэс хоёр болон олон хэлний бичгийн дурсгалууд уламжлагдан ирсний зэрэгцээ, хэд хэдэн хэл, бичиг үсгийг харилцан цэгцэлсэн толь бичгүүд гарч ирсэн байна. Монголчуудаас улбаатай энэхүү орчуулгын соёл нь бусад улс үндэстэнд нөлөөлж, ялангуяа толь бичиг зохиох үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулжээ.

Эрдэмтэн, профессор Л.Манлажав хоёр болон олон хэлний толь бичиг уламжлагдан ирснийг ерөнхийд нь Дорно болон Өрнө зүгт нөлөөлснөөр нь хоёр төрөлд ангилан авч үзжээ. Тухайлбал, “Монгол И-юи” толь бичиг нь нангиад-монгол толинуудын анхдагч бөгөөд монгол хэлний хамгийн анхны толь бичиг хэмээсэн байна.¹⁷⁰ Хубилай хааны үед (1264-1294) зохиосон энэхүү толь бичгийн загвараар [Нангиад-харь хэлний орчуулга үгс] нэртэйгээр монгол хэлнээс гадна, япон, солонгос, зөрчид, уйгур, сиам, төвд зэрэг арав гаруй хэлний толь бичиг хожим нь гарчээ.¹⁷¹

Мөн Өрнөдөд толь бичиг зохиох үйлсэд монголчууд түлхэц өгсөн байна. Үүний гэрч нь “*Codexcumanicus*” гэж нэрлэгддэг латин-перс-куман гурамсан хэлний толь бичиг юм.¹⁷² “*Codexcumanicus*” толь бичигт үг хэллэгүүдээс гадна, хэлзүйн дүрэм, куман хэлээр бичсэн шашны холбогдол бүхий бичвэрүүд, мөн герман, куман хэлээр бичсэн зарим нэг шигтгээс зэрэг зүйлс оржээ. Уг толийг зөвхөн латин үсгээр бүтээсэн ажээ. “*CodexCumanicus*”-т Баруун түрэгийн бичгийн хэлнүүдээс оруулалгүй, харин баруун зүгийн түрэг хэлний янз бүрийн нутгийн аялгууны үгсийг оруулжээ. Мөн үүнтэй нэгэн адилаар олон хэлний толь бичиг болох “*Муккадитат-аль-Адаб*” –ын

¹⁶⁹ Р.Гүрбазар. Орчуулгын онол дадлагын үндэс, УБ, 1996, 57-р тал.

¹⁷⁰ Л.Манлажав. “Орчуулгын үйлсэд монголчуудын оруулсан хувь нэмэр” “Оноогүй орчуулгын алдаа мадагийг тунгаан ярилцах нь” ном, УБ, 2008, 15-р тал.

¹⁷¹ Мөн тэнд.

¹⁷² Мөн тэнд.

хэмээх араб үсгээр бичсэн араб-перс-турк-монгол хэлний толь бичгийг мөн дурдах учиртай.¹⁷³

Дундад зууны үеэс улбаатай толь бичиг зохиох ажил XX зуунд ч үргэлжилж Я.Цэвэл, Х.Лувсанвандан, С.Лувсандэндэв зэрэг нэртэй эрдэмтэн хэл шинжээчид олон арван толь зохиосныг дурдах нь зүйтэй.

Гуравт, орчуулгын онолын уламжлал

Монголын гүүш эрдэмтэд зөвхөн орчуулга хийгээд зогсохгүй орчуулгын онол зарчим чанарын асуудалд анхаарлаа хандуулж судалсаар иржээ. Орчуулгын үүсэл хөгжлийг хүн төрөлхтөн үүссэн цаг үетэй холбож үздэг бол орчуулгын тухай шинжлэх ухаан буюу орчуулгын онолыг зарим судлаачид харьцангуй хожуу буюу XX зууны 2-р хагасаас эхлэлтэй гэж үздэг. Тэгвэл нүүдэлчин монголчуудын хувьд орчуулгын онол зарчмын асуудлыг тэртээх XVIII зууны үеэс нухацтай авч үзэх болсон байна. Үүний баталгаа нь дээр өгүүлсэн “Мэргэд гарахын орон нэрт тогтоосон даяг” толь бичиг юм.

Энэхүү толь бичгийн ард орчуулгын ерөнхий зарчим, орчуулгын үгсийн сангийн асуудал, орчуулгын найруулга зүй зэрэг орчуулгын онолын асуудлыг тайлбарлаж чаджээ. Тухайлбал, “... Утга дор гэм үл болох бээр илүү үгийг огоорч болох бөгөөд зарим үе дор үгсийг өчүүхэн нэмбээс утгын гадас бүрдэх мэт ч буйн тул түүний утгыг тодорхойлох дор тусад бөгөөд төвөг үл болох үг өчүүхэн нэмж орчуулах” гэсэн нь орчуулгын орхих нэмэх аргыг тодорхойлжээ.¹⁷⁴

Түүнчлэн уг толь бичигт орчуулагч хүн эргэлзэж тээнэгэлзсэн үгээ нэрлэхэж цээрлэлгүй мэдэх хүнээс асуух, аливаа зүйлийг дураар нэрлэхгүй байх, уншиж мэдэхэд амар хялбар нийтийн мэдэх утга дүйсэн, жин таарсан үгийг сонгож олох, тухайн үг нь урьд хойд үгтэйгээ харшлахгүй байх, зарим газар өгүүлбэрийн утга санаанд нөлөөлөхөөргүй үгийг орхиж, зарим газар утга тодруулах үг нэмж болно гэх зэргээр орчуулагч хүнд тавигдах шаардлагын асуудлыг ч тодорхой хөндөн авч үзсэн нь өнөөгийн өндөрлөгөөс эргэн харахад туйлын бахархууштай.

Цаашлаад хүн, газар ус, цэцэг жимсний нэрийг орчуулахдаа эх зохиол дээрх нэрийг тэр чигээр нь тавиад ар талд нь уул тал буюу цэцэг жимс гэсэн тайлбар бичихийг зөвлөсөн нь тухайн оноосон нэрийг буруу зөрүү буулгаж, нэг ёсондоо авиа зүйн орчуулгыг зөв хийхийг анхааруулсан чухал ач холбогдолтой зүйл юм.

Орчуулахдаа зохиогчийн санааг алдагдуулахгүй байх, сайжруулах нэрийдлээр хүний зохиолыг засахгүй байх /зохиогчийн эрхийн асуудал Б.Э/, зохиогчийн далд утгатай бичсэнийг ил утгатай болгохгүй байх зэрэг анхаарвал зохих олон зүйлийг дурдсан нь олон хэлнээс орчуулга хийж байгаа одоо үед ч үнэ цэнээ алдаагүй байна.

“Европ дахинд 1827 онд Англи улсын Лондон хотод хэвлэгдсэн “The first book of Virgil’s Aeneid with a literal Interliner translation” нэртэй анхны орчуулгын сурах бичиг бол грек хэлнээс англи хэлэнд орчуулах сурагчдад зориулсан хадмал гарын авлага байлаа. Тэгвэл монголчууд Европ дахинаас 85 жилийн өмнө “Мэргэд гарахын орон” хэмээх орчуулгын онолын сурах бичгийг бүтээсэн гэсэн үг юм.”¹⁷⁵

¹⁷³ Мөн тэнд.

¹⁷⁴ Р.Гүрбазар. “Орчуулгын онол дадлагын үндэс” УБ, 1996, 50-р тал.

¹⁷⁵ Л.Чулуунбаатар. “Орчуулгын сургууль болон орчуулгын онолын сурах бичгийн тухай”. “Орчуулах эрдэм-IV ном, УБ, 2012 56-р тал.

XX зуун бол манай орчуулгын онол судлалын хүрээнд багагүй амжилт гарсан үе билээ. Орчуулгын онолын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан эрдэмтэд бол Б.Ринчен, Ц.Дамдинсүрэн нар билээ.

Орчуулгын зангилаа асуудлыг нухацтай шүүн хэлэлцэх талаар 1970-аад оноос ахиц гарч С.Галсан, Ц.Цэдэндамба, Д.Дашдаваа, Г.Аким, А.Шархүү, Р.Гүрбазар зэрэг судлаач эрдэмтэд орчуулгын онолын зарим тулгамдсан асуудлыг хөндөж шинэ санаа дэвшүүлэх болсон нь орчуулгын сэтгэлгээнд чухал алхам болсон билээ..

Дөрөвт, орчуулгын дэг, сургуулийн уламжлал

Аливаа салбарт мэргэжлийн боловсон хүчин бэлдэх явдал нэн тэргүүний зорилт байдгийн адил монголчууд ч орчуулгатай зэрэгцэн орчуулах чадвартай, тухайн хэлний мэдлэгтэй хүмүүсийг бэлдэхэд үе үедээ анхаарсаар иржээ.

Монгол оронд орчуулгыг шавь сургалтын аргаар эзэмшүүлж байсан баримт байна. XVIII зууны үеэс бичиг үсгийн чадвартай хүмүүс цөөн байснаас албаны бичээч нар хомсдож, бичээч болгох зорилгоор бага насны хүүхдийг монгол, манж бичигт сургах болжээ. Мөн хятад хэл, бичгийн мэдлэгтэй хүн шаардлагатай болсон учир Өргөөд манж, хятад бичгийн сургууль байгуулж хүүхэд сургах болсон байна.

XIX зууны эцэс XX зууны эхнээс Оросууд Монгол, Хятадыг сонирхох болсон, үүнтэй уялдан Монгол-Оросын харилцаа өрнөж эхэлсэн: үүнд, Хүрээнд Оросын консулын газар байгуулагдсан, оросууд суурьшиж эхэлсэн зэргээс шалтгаалан зөвхөн манж, хятад төдийгүй орос хэлтэй хүмүүс хэрэгцээтэй болжээ. Иймд 1864 оны 11 сарын 1-нд Консулын газрын дэргэд орчуулагч, хэлмэрчийн сургуулийг анх нээсэн байна.¹⁷⁶ Хиагтын Орос-Монгол сургуульд мөн орчуулагчдыг бэлддэг байжээ. Орчуулагчдын хэрэгцээ улам бүр нэмэгдэж байгааг харгалзан Консулын газар хувийнхаа хөрөнгөөр суралцах сонсогч-орчуулагчдыг бэлдэх болсон байна. Энэ сургуульд манж, монгол хэлэнд боловсорсон монгол бичгийн хүмүүс хичээл зааж байжээ. Өргөөгийн орчуулагч, хэлмэрчийн сургууль 50 гаруй жил оршин тогтнохдоо 100 гаруй орчуулагч төгсгөжээ.¹⁷⁷ Түүнийг төгсөгчид Монгол, Хятад, Манжийн төр, засгийн байгууллагууд, Алс Дорнод, Дорнод Сибирийн төрөл бүрийн байгууллагуудад ажиллаж байв. Энэ сургуулийг төгссөн орчуулагчид дипломат хэлэлцээрүүдэд оролцдог, гэрээ бичгийн эх боловсруулан бэлтгэдэг байв. Мөн Жамсраны Цэвээн энэ сургуульд багшилдаг байжээ.¹⁷⁸

Тавд, монгол хэл олон улсын харилцаанд хэрэглэгдэж байсан уламжлал

Нэгэнтээ орчуулагч Г.Аким орчуулгын талаарх өгүүлэлдээ Монголын эзэнт гүрний үед монгол хэл олон улсын нэгэн хурлын ажлын хэл болж байсан тухай дурдсан байсан. Эзэнт гүрний бүрэлдэхүүнд байсан Алтан ордны үед ч харилцааны болон бичиг хэргийн хөтлөлтөд монгол хэл хэрэглэгдэж байсан тухай өгүүлсэн зүйл байдаг.

Энэ мэтчилэн засаг захиргааны болон дипломат харилцаанд монгол хэлийг өргөн хэрэглэж байсныг Ази, Европын олон оронд хадгалагдан үлдсэн баримтууд

¹⁷⁶ Л.Чулуунбаатар. "Орчуулгын сургууль болон орчуулгын онолын сурах бичгийн тухай". "Орчуулах эрдэм-IV ном, УБ, 2012 62-р тал.

¹⁷⁷ Мөн тэнд.. 64-р тал.

¹⁷⁸ Мөн тэнд. 65-р тал.

нотлох бөгөөд эдгээр харилцааны бичгүүд нь дэлхийн олон улс орон, бүс нутгуудад хадгалагдаж байна. Эрдэмтэн Л.Манлажавын жишээ болгон авснаар Ватиканы нууц архивт Гүюг хаанаас Пап ламтаны захианд хариу болгож илгээсэн албан захидал, Абага хаанаас гаргасан албан татвараас чөлөөлөх тухай захидал, Аргун болон Газан хааны захидлууд уг эхээрээ хадгалагдаж байна.¹⁷⁹ Мөн Францын Парис хотод Ил хаан Аргун болон Өлзийт хаадаас Францын ван Гоо Филиппэд тус тус бичсэн захидлууд хадгалагдаж байдаг байна. Профессор Л.Манлажавын үзэж буйгаар Иран улсын Тегеран хотод мөн дээр дурдсан захидлуудтай утга ойролцоо монгол бичгийн дурсгалын зүйлс үлдсэн байдаг бөгөөд БНХАУ-д Их Монгол Улс болон Юань гүрний үеийн бичгийн дурсгалууд үлэмжхэн хэмжээгээр хадгалагдан ирсэн нь тодорхой.

Энэ бүхэн нь монгол хэл Их Монгол Улсын үед төрийн болон гадаад харилцааны албан ёсны хэлний үүрэг гүйцэтгэж байсны тодорхой илрэл мөн.

Түүнчлэн Монголын үе үеийн хаадын ордонд олон хэл эзэмшсэн хүмүүс ажиллаж хэлмэрч дуун хөрвүүлэгчийн үүрэг гүйцэтгэж аман орчуулга хийж байсан нь монгол хэл дипломат харилцаанд өргөн хэрэглэгдэж байсны бас нэг баталгаа болж байна.

Зургаад, орчуулгын чанар болоод орчуулагчдын хариуцлагын уламжлал

Монголчууд хэзээнээс ном эрдмийг дээдлэн үзэж ирсний нэгэн илрэл нь орчуулгын чанар чансаанд ихээхэн анхаарал тавьж дахин дахин нягталдаг сайхан уламжлалтай байжээ. Тухайлбал, тэртээ дундад зуунд ихэнх эрдэмтэн-орчуулагчид орчуулга хийгээд төгсгөлд нь уг зохиолыг хэний зарлиг даалгавраар, хэзээ хаана орчуулж дуусгасан болон барлуулсан, хэн ариутган шүүсэн тухай бичдэг байжээ. Жишээ нь: XVIII зууны бичгийн их хүн Гүүш Цорж нэгэн орчуулгынхаа төгсгөлд:

Орчуул хэмээн олон дурдсанаар

Олон сонссон Ширээт гүүш Цорж

Үргэлжид амьтнаа тус болохыг хичээж

Уран найруулан монгол аялгуугаар орчуулбай.

Тас хэлт Санжа Дондов гүүш бээр

Тансаг үгийг найруулан тохиолдуулж...¹⁸⁰ гэжээ

XX зуунд нэн ялангуяа уран зохиолын орчуулгын эрчимтэй үе байсан гэж болох 1960-80-аад оны төгсгөл хүртэл орчуулах болон орчуулгыг нягталж хянах ажил тухайн үеийн нам, төрийн шууд хяналтан дор явагддаг байсан гэж үзэж болно. Тэр үед Хэвлэлийн нэгдсэн редакци гэж байгууллага байсан бөгөөд улс төрийн болон уран зохиолын орчуулгын бие даасан хоёр хэлтэстэй байсан юм. Эдгээр хэлтсийн орчуулагч, редакторууд ном зохиолыг төлөвлөгөөний дагуу өөрсдөө орчуулахын зэрэгцээ бусдын орчуулгыг хянаж нягтлах хариуцлагатай ажлыг гүйцэтгэдэг байсан. Энэхүү редакцид тухайн үедээ маш өргөн хүрээний мэдлэгтэй шилдэг орчуулагч, эрдэмтэн, зохиолчид байнга хүрэлцэн ирж орчуулж буй зохиол бүтээлийнхээ талаар ярилцдаг, харилцан санал солилцдог байсны зэрэгцээ үг сонголт, үг оноох талаар маргадаг мэтгэлцдэг

¹⁷⁹ Л.Манлажав. "Орчуулгын үйлсэд монголчуудын оруулсан хувь нэмэр", "Оноогүй орчуулгын алдаа мадагийг тунгаан ярилцах нь" ном, УБ, 2008, 14-р ТАЛ.

¹⁸⁰ Р.Гүрбазар. Орчуулгын онол дадлагын үндэс, УБ, 1996, 42-р тал.

сайхан уламжлалтай байсныг мөхөс би хүүхэд, залуу байхдаа нүдээр үзэж, чихээр сонсож байсныгаа одоо санахул ихээхэн аз, том хувь заяа гэж баярлан дурсаж явдаг.

Аливаа орчуулгад бүхий л оюун чадал, ухамсар мэдлэгээ зориулдаг, орчуулгаа заавал эргэж нягталдаг, мэргэжлийн орчуулагч туршлагатай хүнээр засуулж, үзүүлдэг энэхүү уламжлал өнөөдөр зарим талаар алдагдаад редакторгүй, хянан тохиолдуулсан хүнгүйгээр, нэг үгээр, шүүлтүүргүйгээр дан өөрийн нэрийг тавиад шууд хэвлүүлдэг зоригтой “орчуулагчид” мэр сэр байгааг анхаарч урд уламжлалаа сэргээмээр байна.

Эцэст нь, Монголын орчуулгын дээр тоймлон авч үзсэн баялаг уламжлалыг дахин сэргээж цааш үргэлжлүүлэх нь орчуулагч, эрдэмтэд, хэл шинжлэлийн мэргэжилтнүүд болон орчуулга оролдогч хэн бүхний зайлшгүй гүйцэтгэх үүрэг болоод байна.

Summary

In the paper, some important issues related to the tradition of Mongolian translation such as translated works, theory of translation, lexicography, training of translators, level and quality of Mongolian translation as well as Mongolian language as a working language of diplomatic relations have been reviewed by the author.

The author focuses on some issues of rich tradition of both Mongolian translation and experienced translators on the basis of historical facts in comparison with today's translation.

Ашигласан ном зохиол

1. Р.Гүрбазар. Орчуулгын онол дадлагын үндэс. УБ, 1996.
2. Оноогүй орчуулгын алдаа мадагийг тунгаан ярилцах нь. /илтгэл өгүүллийн эмхтгэл. МУИС, ОУХС, Дипломат Орчуулгын Тэнхим, УБ, 2008.
3. Орчуулах эрдэм-II. Илтгэл өгүүллийн эмхтгэл. МУИС, ОУХС, Дипломат Орчуулгын Тэнхим, УБ, 2010.
4. Орчуулах эрдэм-III. Мөн цуврал, УБ, 2011.
5. Орчуулах эрдэм-IV. Мөн цуврал, УБ, 2012.
6. B.Dashtseren. The History and Culture of Mongolia. Calcutta, New Asian Printers, 1997.
7. B.Enkhbayar. "Buddhist Literature in Mongolia". Contribution of Buddhism to World Culture. Vol.1, номонд Somaiya Publications Pvt.Ltd, Mumbai, New Delhi, p.p.355-362.